



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/605

Мөрөн сум

Одон медалиар шагнуулах
санал уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.19, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төр нийгэм, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан иргэдийг Монгол Улсын Төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжилсугай.

2.Төрийн дээд одон медалиар шагнуулахаар уламжлах иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд нэр дэвшигчдийн тодорхойлолт, холбогдох баримт бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам- Өсөх)- т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 11 дугаар
сарын 08-ний өдрийн 11/602 дүгээр
захирамжийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ДЭЭД ОДОНГООР ШАГНУУЛАХААР ТОДОРХОЙЛОГДСОН ИРГЭДИЙН НЭРС

№	Овог	Нэр	Харьяалал	Тодорхойлж буй шагналын нэр
1	Жамъянрис	Пүрэвжал	Бүрэнтогтох сумын ахмад настан	Сүхбаатар одон
2	Товуу	Зундуй	Мөрөн сумын ахмад настан	Гавьяат нисгэгч
3	Агваан	Энхбаяр	Аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан	Цэргийн гавьяаны улаан тугийн одон
4	Баяндорж	Чулуунбаатар	Хөвсгөл тэнгэр ХХК-ийн хувийн мал эмнэлэгт малын их эмч	Алтан гадас
5	Долгорсүрэн	Нямжав	Мөрөн сумын техникийн захад сэлбэг хэрэгслийн худалдагч	Алтан гадас
6	Гомбожав	Шагдаржав	Мөрөн сумын ахмад настан	Алтан гадас
7	Намжилдорж	Цэрэнбал	Мөрөн сумын ахмад настан	Алтан гадас
8	Санжаа	Бямбахүү	Аймгийн Цагдаагийн газрын ахмад ажилтан	Цэргийн гавьяаны одон
9	Гүнсэн	Баасанжав	Цагаан- Уул сумын ахмад настан	Хөдөлмөрийн хүндэт медаль
10	Норов	Бүдханд	Цагаан- Уул сумын ахмад настан	Хөдөлмөрийн хүндэт медаль

— оОо —